

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД, ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ГАЗРЫН ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2004 оны 09 сарын
17 өдөр

Дугаар 213, 157

Маягт шинэчлэн батлах тухай

“Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 7.2 дахь заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1. Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 171/111 тоот хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан нийтлэг хэрэглэгдэх тооцооны маягт /НХМаягт Т-1/-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан маягтыг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтэс, татварын албадын дарга нарт, энэ талаар мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйн газар /Л.Дондог/-т, Үндэсний статистикийн газрын Макро эдийн засаг, бизнес статистикийн газар /А.Дэмбэрэл/-т тус тус даалгасугай.

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН
САЙД

Ч.УЛААН

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ГАЗРЫН ДАРГА

П.БЯМБАЦЭРЭН

